

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/015/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amariargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272287 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
5.2 Албан шаардлага	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГУМС	Засгийн газрын удирдлага мэдээллийн систем
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА С. ЦАГААНБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дээд шатны төсөвт тодотгол хийснээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 30,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 562,197.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Цээл сум нь 17 нэр төрлийн 562,197.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 667,258.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 118.0 хувь буюу 105,060.4 мянган төгрөгөөр давж биелсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл 11 нэр төрлийн орлого 132,528.6 мянган төгрөгөөр давж, 7 нэр төрлийн орлого 27,468.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Цээл сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ нь 8 зорилт, 31 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батламжлагдсанаас гүйцэтгэлээр 26 арга хэмжээг 96,7 хувь, 5 арга хэмжээг 90,7 хувьтай хэрэгжүүлсэн байна. Нийт үнэлгээгээр 93,7 хувьтай буюу "Үр дүнд хүрсэн" гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

• 4126020589

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
			2024.12.31	2025.12.31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,099,600.58	1,241,107.7
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	683,115.76	721,726.58
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	246,530.09	264,174.51
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	146,950.65	243,798.28
5	НӨӨЦИЙН БАРАА	9а	23,004.08	11,408.33
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		10,482,212.48	10,462,033.6
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	10,482,212.48	10,462,033.6
8	Биет хөрөнгө		2,082,720.48	2,064,874.93
9	Биет бус хөрөнгө	13	8,399,492	8,397,158.67
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		11,581,813.06	11,703,141.29
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР		4,957.26	50,708.05
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		4,957.26	50,708.05
13	Өглөг		4,957.26	50,708.05
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		11,576,855.8	11,652,433.25
15	Засгийн газрын хувь оролцоо		11,576,855.8	11,652,433.25
16	Засгийн газрын оруулсан капитал		716,990.22	716,990.22
17	Хуримтлагдсан үр дүн		10,544,795.02	10,620,527.45
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		315,070.57	314,915.58
19	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		11,581,813.06	11,703,141.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
			2024.12.31	2025.12.31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		10,666,165.16	2,474,299.43
2	ТАТВАРЫН ОРЛОГО		592,708.1	643,488.99
3	Орлогын албан татвар		468,990.97	491,437.3
4	Хувь хүний орлогын албан татвар		468,990.97	491,437.3
5	Хөрөнгийн албан татвар		48,276.78	55,114.08
6	Бусад татвар, төлбөр, хураамж		75,440.35	96,937.61
7	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	8,403,875.83	1,830,810.44
8	Тусламжийн орлого		0.0	1,239,185.38
9	Зээлийн орлого		0.0	159.6
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,669,581.23	0.0
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,121,694.05	2,101,289.25
12	УРСГАЛ ЗАРДАЛ		1,924,298.7	2,040,677.56
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,895,047.79	1,974,120.16
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		737,044.52	898,138.35
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		96,566.36	107,634.23

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		569,760.18	533,450.82
17	Хангамж, бараа материалын зардал		53,838.48	44,878.67
18	Нормативт зардал		129,053.95	111,199.51
19	Эд хогшил, урсгал засварын зардал		56,698.4	32,607.8
20	Томилолт, зочны зардал		11,476	13,550
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		17,816.09	6,465.83
22	Бараа үйлчилгээний бусад зардал		222,793.82	226,194.94
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		29,250.91	66,557.41
24	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		197,395.35	60,611.69
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		8,544,471.11	373,010.18
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		176,058.59	297,645.75
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-176,058.59	-297,645.75
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		8,368,412.52	75,364.43

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	/мянган төгрөгөөр/	
			Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,208,443.28		3,208,443.28
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,208,443.28		3,208,443.28
3	Тайлант үеийн үр дүн	8,368,412.52		8,368,412.52
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,576,855.8		11,576,855.8
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,576,855.8		11,576,855.8
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	368.01		368.01
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,577,223.81		11,577,223.81
8	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-154.99		-154.99
9	Тайлант үеийн үр дүн	75,364.43		75,364.43
10	2025 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,652,433.25		11,652,433.25

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Дансны нэр, төрөл	/мянган төгрөгөөр/	
		2024.12.31	2025.12.31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,551,374.86	2,409,206.63
2	ТАТВАРЫН ОРЛОГО	592,708.1	643,488.99
3	Орлогын албан татвар	468,990.97	491,437.3
4	Хөрөнгийн албан татвар	48,276.78	55,114.08
5	Бусад татвар, төлбөр, хураамж	75,440.35	96,937.61
6	Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,129.24	13,840.41
7	Газрын төлбөр	58,462.07	81,652.72
8	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,849.04	1,444.48
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	290,886.63	1,765,717.64
10	Нийтлэг татварын бус орлого	290,886.63	247,204.15
11	Тусламжийн орлого	0.0	1,239,185.38
12	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	279,328.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,667,780.13	0.0
14	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,760,363.39	1,936,143.49
15	УРСГАЛ ЗАРДАЛ	1,760,363.39	1,936,143.49
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,729,827.83	1,868,972.55
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	742,618.89	897,762.52
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,233	107,634.23
19	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	569,760.18	533,960.82
20	Хангамж, бараа материалын зардал	41,299.71	23,102.05
21	Нормативт зардал	108,344.57	115,112.13
22	Эд хогшил, урсгал засварын зардал	57,990	73,038.75
23	Томилолт, зочны зардал	11,476	5,450
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,876.41	57,587.54
25	Бараа үйлчилгээний бусад зардал	88,229.08	55,324.52
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,535.56	67,170.93
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	791,011.47	473,063.14
28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	491,348.7	322,952.33
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	491,348.7	322,952.33
30	Дотоод эх үүсвэрээр	491,348.7	322,952.33
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-491,348.7	-322,952.33
32	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	101,436.71	111,499.98
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-101,436.71	-111,499.98
34	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	198,226.06	38,610.82
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	484,889.7	683,115.76
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	683,115.76	721,726.58

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны нэр, төрөл	/мянган төгрөгөөр/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,708,104.00	3,893,801.70	185,697.70	105.01
Татварын орлого	544,697.70	643,489.00	98,791.30	118.14
Орлогын албан татвар	422,507.30	491,437.30	68,930.00	116.31
Хөрөнгийн албан татвар	60,910.00	55,114.10	-5,795.90	90.48
Бусад татвар, төлбөр, хураамж	61,280.40	96,937.60	35,657.20	158.19
Татварын бус орлого	3,163,406.30	3,250,312.70	86,906.40	102.75
Нийтлэг татварын бус орлого	129,000.00	127,039.40	-1,960.60	98.48
Тусламжийн орлого	2,753,352.70	2,843,945.20	90,592.50	103.29
Аймаг нийслэлээс авсан татаас	1,096,827.50	1,096,827.50	-	100
Төсвөөс санхүүжих	1,656,525.20	1,747,117.70	90,592.50	105.47
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	281,053.60	279,328.10	-1,725.50	99.39
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	281,053.60	279,328.10	-1,725.50	99.39
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,580,720.50	3,871,944.60	1,291,224.10	150.03
УРСГАЛ ЗАРДАЛ	1,797,346.20	3,441,902.30	1,644,556.10	191.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,728,078.20	1,627,613.60	-100,464.60	94.19
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	812,267.10	797,185.70	-15,081.40	98.14
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,499.30	95,655.50	-4,843.80	95.18
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	541,178.50	533,960.80	-7,217.70	98.67
Хангамж, бараа материалын зардал	28,950.00	18,983.90	-9,966.10	65.57
Нормативт зардал	2,390.00	2,251.20	-138.8	94.19
Эд хогшил, урсгал засварын зардал	87,884.80	72,499.10	-15,385.80	82.49
Томилот, зочны зардал	9,446.00	4,610.00	-4,836.00	48.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,500.00	57,543.00	-24,957.00	69.75
Бараа үйлчилгээний бусад зардал	62,962.50	44,924.50	-18,038.00	71.35
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,268.00	1,814,288.60	1,745,020.60	2,619.23
Бусад урсгал шилжүүлэг	69,268.00	67,170.90	-2,097.10	96.97
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	671,874.30	318,542.30	-353,332.00	47.41
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	111,500.00	111,500.00	0	100
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,127,383.50	21,857.10	-	1.94
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-1,127,383.50	-21,857.10	1,105,526.40	1.94
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,127,383.50	-21,857.10	1,105,526.40	1.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	608,847.40	608,847.40	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	641,944.90	641,944.90	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	64	58	6	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0	

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн байгууллага	2	2	0	
АЖИЛЛАГСДЫН ТОО	31	28	3	
Удирдах ажилтан	10	10	0	
Гүйцэтгэх ажилтан	14	11	3	
Үйлчлэх ажилтан	6	6	0	
Гэрээт ажилтан	1	1	0	
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31	28	3	
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	8	3	
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	0	
Гэрээт ажилтан	1	1	0	
Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	0	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	309,485.50	131,117.47
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	309,485.50	131,117.47
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	113,268.16
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	278,925.80	5,397.61
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,559.70	12,451.70
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	309,485.50	131,117.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,434.70	126,707.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,799.60	126,707.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	82,073.00	100,576.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,631.10	11,978.73
2104	Хангамж, бараа материалын зардал	9,123.20	2,992.18
2105	Нормативт зардал	0.00	220.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	539.70
2107	Томилолт, зочны зардал	3,492.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,433.30	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,047.00	10,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	162,050.80	4,410.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,635.10	0.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 125,502.1 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлснийг дараах байдлаар шийдвэрлэлээ.

1.1 Залруулсан алдаа

Цээл сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг шалгаж үзэхэд эмийн эргэлтийн сангийн 125,502.1 мянган төгрөгийн тайлан нэгтгэл тайланд тусгагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

1.2 Залруулаагүй алдаа

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 13,991.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9,878.0 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл татварын албанаас ирүүлсэн гүйцэтгэлийн мэдээтэй 11,475.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил бүтэн жилээр бэлтгэж тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт 1:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх

Засаг даргын нөөц /81102/210901/ зардлаас 2,515.6 мянган төгрөгийг спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Засаг даргын нөөц хөрөнгийг холбогдох хууль, журамд заасан зориулалтын дагуу зарцуулах, спортын уралдаан, тэмцээний зардлыг тухайн зориулалтын төсвийн ангилалд (соёл, спортын арга хэмжээний зардал) тусган, батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх.

Илрүүлэлт 2:

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөгөөр 562,197.7 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 667,258.1 мянган төгрөг төвлөрүүлсэн ба 7 нэр төрлийн орлого 27,468.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу, орлогын нэр төрөл бүрээр жигд биелүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" заалтын дагуу ирүүлж, зөвлөмж болон албан шаардлагын биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй	7	8				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	5	1	4		1			

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	125,502.2	1	125,502.2	0	-	1	125,502.2		
Засаг даргын Тамгын газар	4	79,971.1	4	79,971.1	0	-	4	79,971.1		
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	24,989.2			1	24,989.20	1	24,989.2		
Дүн	6	230,462.5	5	205,473.3	1	24,989.20	6	230,462.5	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	3	41,458.7	-	-	1	11,475.0	2	29,983.7
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	3,163.9	1	2,623.9	1	540.0		
Засаг даргын Тамгын газар	5	9,110.8	2	2,791.2	1	3,879.6	2	2,440.0
Хоршоо хөгжүүлэх сан	1	1,255.9	-	-	-	-	1	1,255.9
Эмийн эргэлтийн сан	1	971.3	-	-	-	-	1	971.3
Дүн	12	55,960.6	3	5,415.1	3	15,894.6	6	34,650.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны тухай хуулийн	1						1			

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хэрэгжилт хангалтгүй										
Дүн	1		0	0		0	1	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn